Тендерийн урилга

Огноо: 2026 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр

Зээл/Буцалтгүй тусламжийн дугаар ба нэр: L3895/L3896-MON Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төсөл

Гэрээний дугаар ба нэр: CW-9-1 Үрийн судалгааны байгууламж болон услалтын систем сайжруулах барилгын ажил (Зүүнхараа)

1. Монгол Улс нь Азийн хөгжлийн банк (АХБ)-аас Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төслийг санхүүжүүлэх зорилгоор энэхүү санхүүжилтийг хүлээн авсан бөгөөд уг хөрөнгөөр дээр дурдсан гэрээний төлбөрийг санхүүжүүлэх зорилготой болно. Тендер шалгаруулалт нь АХБ-ны эрх бүхий орны тендерт оролцогчдод нээлттэй байна.

2. Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам ("Захиалагч") нь эрх бүхий тендерт оролцогчийг Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн харъяа Зүүнхараа услалтын системийг шинэчлэн сайжруулах барилгын ("Ажил гэх") ажлын барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэх, дуусгах тухай битүүмжилсэн санал ирүүлэхийг урьж байна.

3. Нээлттэй өрсөлдөөнт тендер шалгаруулалт (дотоодод зарлан мэдээлэх)-ыг АХБ-ны *нэг үе шаттай: нэг дугтуйт* горимын дагуу зохион байгуулах ба тендерийн баримт бичигт заасан эрх бүхий орны бүх тендерт оролцогчдод нээлттэй байна.

4. Энэхүү тендер шалгаруулалтад зөвхөн дор дурдсан чадварын үндсэн шаардлагыг хангасан эрх бүхий тендерт оролцогч оролцоно. Үүнд:

1) Сүүлийн 3 (2022, 2023, 2024) жилийн барилгын ажлын жилийн дундаж борлуулалтын хэмжээ 593,000,000.00 төгрөг,
2) Сүүлийн 3 (2022, 2023, 2024) жилд гүйцэтгэж дуусгасан ижил төстэй нэг гэрээт ажлын үнэлгээ нь 296,460,000.00 төгрөгөөс доошгүй байх
3) Санхүүгийн нөөц хөрөнгийн шаардлага:

А. Ганц оролцогч бол:

САН-3 маягтад заасан санхүүгийн нөөц хөрөнгө нь САН-4 маягтад дурдсан, одоо хэрэгжиж буй гэрээний үүргийн дүнг оруулаагүй хэмжээгээр 98,900,000.00 төгрөг бүхий энэхүү гэрээний нийт шаардлагыг хангах эсхүл давуулан хангах боломжтой эсэхийг тендерт оролцогч нотлон харуулах ёстой,

Б. Түншлэл бол:

(1) САН-3 маягтад заасан санхүүгийн нөөц хөрөнгө нь САН-4 маягтад дурдсан одоо хэрэгжиж буй гэрээний үүргийн дүнг оруулаагүй хэмжээгээр уг гэрээний нийт шаардлагын 40 хувийг хангах эсхүл давуулан хангах боломжтой эсэхийг нэг гишүүн нотлон харуулах ёстой МӨН

(2) САН-3 маягтад заасан санхүүгийн нөөц хөрөнгө нь САН-4 маягтад дурдсан одоо хэрэгжиж буй гэрээний үүргийн дүнг оруулаагүй хэмжээгээр уг гэрээний нийт шаардлагын 25 хувийг хангах эсхүл давуулан хангах боломжтой эсэхийг гишүүн бүр нотлон харуулах ёстой МӨН

(3) САН-3 маягтад заасан санхүүгийн нөөц хөрөнгө нь САН-4 маягтад дурдсан одоо хэрэгжиж буй гэрээний үүргийн дүнг оруулаагүй хэмжээгээр 98,900,000.00 төгрөг бүхий энэхүү гэрээний нийт шаардлагыг хангах эсхүл давуулан хангах боломжтой эсэхийг түншлэл нотлон харуулах ёстой.

4) Ажил гүйцэтгэхэд шаардагдах тусгай зөвшөөрөл: “шаардлагатай” Тусгай зөвшөөрлийн ялгах дугаар ба нэр: Барилга хот байгуулалтын сайдын 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 147 дугаар тушаалаар батлагдсан суурь нөхцөл, шаардлагатай дүйцнэ.

1) БА 3.2 Усны барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил буюу түүнээс дээш ангилалд хамаарах тусгай зөвшөөрөл

5. Монгол хэл дээр боловсруулсан тендерийн баримт бичгийг

- Тендерт оролцогчид цахим худалдан авах ажиллагааны систем (https://tender.gov.mn)-ээс татаж авна.
- Эцсийн хугацаа: 2026 оны 2-р сарын 9-ний өдөр болон түүнээс өмнө цахим серверийн цагаар 10:00 (GMT+8)
- Тендерийн баримт бичигт заасан тендерийн баталгааны хамт.

6. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусмагц тендерийг нэн даруй цахим системээр нээнэ.

7. Захиалагч нь тендерт оролцогчийн тендер бэлтгэх, хүргүүлэхтэй холбогдсон аливаа зардлыг хариуцахгүй.